



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 164

Мандалговь

Хөрөнгө балансаас баланст
шилжүүлэх тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.а, 3 дугаар зүйлийн 3.2.6.б, 5 дугаар зүйлийн 5.1 заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 74'272'000 /далан дөрвөн сая хоёр зуун далан хоёр мянга/ төгрөгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн үндсэн хөрөнгийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэст балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Ч.Ганбаяр, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Ц.Батбилэг нарт тус тус даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ

